



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СБА-2022/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт  
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: [gereltekhburtgelaudit01@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit01@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 98

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ө.БОРГИЛ  
ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>56,580,542.50</u></b>	<b><u>71,379,633.94</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31120	Гадаад валют	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>56,580,542.50</u></b>	<b><u>71,379,633.94</u></b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b><u>938,400.00</u></b>	<b><u>1,276,760.00</u></b>
35130	Эм боох материал	938,400.00	1,276,760.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b><u>54,010,642.50</u></b>	<b><u>55,432,873.94</u></b>
35410	Бичиг хэргийн материал	355,610.00	711,210.00
35420	Аж ахуйн материал	40,683,328.00	45,884,365.04
35430	Хүнсний материала	42,705.00	942,150.00
35440	Түлш, шатах тослох материал	6,190,508.00	1,156,657.40
35470	Бусад хангамжийн материал	6,738,491.50	6,738,491.50
35600	Мал амьтад	<b><u>1,631,500.00</u></b>	<b><u>14,670,000.00</u></b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>740,754,379.73</u></b>	<b><u>712,715,274.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>722,610,379.73</u></b>	<b><u>694,571,274.81</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>722,610,379.73</u></b>	<b><u>694,571,274.81</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	765,161,603.00	739,933,603.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,190,386.72)	(62,943,580.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,000,000.00	37,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,000,000.00)	(37,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	103,448,701.27	104,818,701.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(92,961,319.94)	(98,913,145.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,457,866.67	37,237,866.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,306,084.55)	(27,027,160.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,575,701.20	8,575,701.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,575,701.20)	(8,575,701.20)
93217	Номын фонд	-	1,464,990.48
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>18,144,000.00</u></b>	<b><u>18,144,000.00</u></b>
39301	Програм хангамж	775,000.00	775,000.00
39302	Хасагдуулга	(775,000.00)	(775,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,144,000.00	18,144,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>797,334,922.23</u></b>	<b><u>784,094,908.75</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,719,007.00</u></b>	<b><u>1,880,707.70</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,719,007.00</u></b>	<b><u>1,880,707.70</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b><u>3,719,007.00</u></b>	<b><u>1,880,707.70</u></b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b><u>3,719,007.00</u></b>	<b><u>1,880,707.70</u></b>
41361	Байгууллагад төлөх өглөг	238,800.00	1,880,707.70
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,480,207.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>793,615,915.23</u></b>	<b><u>782,214,201.05</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>793,615,915.23</u></b>	<b><u>782,214,201.05</u></b>

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,140,270,606.97	1,140,270,606.97
51101	Өмч: - төрийн	1,140,270,606.97	1,140,270,606.97
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(346,654,691.74)</b>	<b>(358,056,405.92)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(346,654,691.74)	(346,654,691.74)
51220	Тайлант үеийн үр дүн		(11,401,714.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>797,334,922.23</u></b>	<b><u>784,094,908.75</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>568,439,591.00</b>	<b>564,580,353.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,493,191.00</b>	<b>19,022,317.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,493,191.00</b>	<b>18,202,317.52</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,493,191.00	18,202,317.52
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,493,191.00	18,202,317.52
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>820,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>52,418,400.00</b>	<b>50,095,903.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>-</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	505,528,000.00	495,462,133.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>690,700.00</b>	<b>4,140,036.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,140,036.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	690,700.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>51,727,700.00</b>	<b>45,886,450.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,727,700.00	45,886,450.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>69,417.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	69,417.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>588,556,186.94</b>	<b>575,982,067.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>588,556,186.94</b>	<b>575,982,067.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>526,768,606.44</b>	<b>549,658,600.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>382,852,805.50</b>	<b>416,595,250.00</b>
210101	Үндсэн цалин	281,493,092.27	317,020,717.00
210102	Нэмэгдэл	69,657,002.73	71,071,071.00
210104	Урамшуулал	31,702,710.50	28,503,462.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,606,092.00</b>	<b>46,915,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,875,400.00	32,689,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,250,100.00	3,556,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,100.00	2,845,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,000.00	711,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,230,492.00	7,112,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,945,265.00</b>	<b>36,728,884.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,322,250.00	4,106,928.00

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	37,855,015.00	29,957,656.00
210303	Цэвэр, бохир ус	2,768,000.00	2,664,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,665,000.00</b>	<b>5,290,116.00</b>
210401	Бичиг хэрэг	70,400.00	1,235,416.00
210402	Тээвэр, шатахуун	3,860,000.00	523,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,900.00	375,000.00
210404	Ном, хэвлэл		944,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61,200.00	88,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	928,500.00	2,123,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,028,981.00</b>	<b>5,146,005.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,081,600.00	500,490.00
210502	Хоол, хүнс	9,367,581.00	4,103,475.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	579,800.00	542,040.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>2,157,950.00</b>
210604	Урсгал засвар		2,157,950.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>-</b>	<b>282,000.00</b>
210702	Дотоод албан томилот		282,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,410,700.00</b>	<b>300,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,410,700.00	300,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,259,762.94</b>	<b>36,242,695.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	714,000.00	2,362,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,612,600.00	2,225,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,933,162.94	31,654,095.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,787,580.50</b>	<b>26,323,467.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,919,068.00</b>	<b>19,726,140.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	8,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		636,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,919,068.00	19,081,340.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,160,650.00</b>	<b>431,267.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,160,650.00	431,267.30
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,707,862.50</b>	<b>6,166,060.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,707,862.50	6,166,060.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(20,116,595.94)</b>	<b>(11,401,714.18)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(20,116,595.94)</b>	<b>(11,401,714.18)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,140,270,606.97	(326,538,095.70)	813,732,511.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,140,270,606.97	(326,538,095.70)	813,732,511.27

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C07	Тайлант үеийн үр дүн		(20,116,595.94)	(20,116,595.94)
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,140,270,606.97</b>	<b>(346,654,691.64)</b>	<b>793,615,915.33</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,140,270,606.97</b>	<b>(346,654,691.64)</b>	<b>793,615,915.33</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,140,270,606.97</b>	<b>(346,654,691.64)</b>	793,615,915.33
D08	Тайлант үеийн үр дүн	-	(11,401,714.18)	(11,401,714.18)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,140,270,606.97</b>	<b>(358,056,405.82)</b>	<b>782,214,201.15</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>557,946,400.00</b>	<b>545,558,036.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>557,946,400.00</b>	<b>545,558,036.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	505,528,000.00	495,462,133.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>690,700.00</b>	<b>4,140,036.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,140,036.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	690,700.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>51,727,700.00</b>	<b>45,886,450.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,727,700.00	45,886,450.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>69,417.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	69,417.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>557,946,400.00</b>	<b>544,228,036.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>557,946,400.00</b>	<b>544,228,036.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>496,757,847.50</b>	<b>520,945,558.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>382,816,905.50</b>	<b>417,101,300.00</b>
210101	Үндсэн цалин	281,457,192.27	318,701,800.00
210102	Нэмэгдэл	69,657,002.73	73,868,100.00
210104	Урамшуулал	31,702,710.50	24,531,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,606,092.00</b>	<b>46,915,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,875,400.00	32,689,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,250,100.00	3,556,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,100.00	2,845,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,000.00	711,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,230,492.00	7,112,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,567,050.00</b>	<b>33,294,532.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,322,250.00	4,106,928.00
210302	Түлш, халаалт	39,476,800.00	26,385,304.70
210303	Цэвэр, бохир ус	2,768,000.00	2,802,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,083,430.00</b>	<b>5,416,436.00</b>
210401	Бичиг хэрэг	116,800.00	1,093,936.00
210402	Тээвэр, шатахуун	3,860,000.00	794,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,900.00	375,000.00
210404	Ном, хэвлэл		944,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61,200.00	88,700.00

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300,530.00	2,119,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,815,070.00</b>	<b>9,044,240.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,984,150.00	841,500.00
210502	Хоол, хүнс	9,367,020.00	7,434,040.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	463,900.00	768,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>5,000,000.00</b>
210604	Урсгал засвар		5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>282,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		282,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>896,700.00</b>	<b>592,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	896,700.00	592,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,972,600.00</b>	<b>3,298,950.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,972,600.00	3,298,950.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,188,552.50</b>	<b>23,282,477.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,320,040.00</b>	<b>16,685,150.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		636,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,320,040.00	16,048,350.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,160,650.00</b>	<b>431,267.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,160,650.00	431,267.30
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,707,862.50</b>	<b>6,166,060.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,707,862.50	6,166,060.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b><u>1,330,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>1,330,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,330,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>1,330,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,330,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b><u>(1,330,000.00)</u></b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>540,770,000.00</b>	<b>534,820,672.70</b>	<b>5,949,327.30</b>	<b>98.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>540,770,000.00</b>	<b>534,820,672.70</b>	<b>5,949,327.30</b>	<b>98.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>523,654,600.00</b>	<b>518,135,522.70</b>	<b>5,519,077.30</b>	<b>98.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>417,101,300.00</b>	<b>417,101,300.00</b>	-	<b>100.00</b>
210101	Үндсэн цалин	321,283,800.00	318,701,800.00	2,582,000.00	99.20
210102	Нэмэгдэл	71,286,100.00	73,868,100.00	(2,582,000.00)	103.62
210104	Урамшуулал	24,531,400.00	24,531,400.00	-	<b>100.00</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,867,100.00</b>	<b>46,915,500.00</b>	<b>4,951,600.00</b>	<b>90.45</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,733,900.00	32,689,700.00	5,044,200.00	86.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,533,300.00	3,556,900.00	(23,600.00)	100.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,826,700.00	2,845,000.00	(18,300.00)	100.65

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	706,700.00	711,000.00	(4,300.00)	100.61
210205	Эрүүл мэндийн даатгал	7,066,500.00	7,112,900.00	(46,400.00)	100.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,725,800.00</b>	<b>33,294,532.70</b>	<b>431,267.30</b>	<b>98.72</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,446,700.00	4,106,928.00	1,339,772.00	75.40
210302	Түлш, халаалт	25,476,800.00	26,385,304.70	(908,504.70)	103.57
210303	Цэвэр, бохир ус	2,802,300.00	2,802,300.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,511,200.00</b>	<b>3,868,550.00</b>	<b>642,650.00</b>	<b>85.75</b>
210401	Бичиг хэрэг	591,300.00	462,150.00	129,150.00	78.16
210402	Тээвэр, шатахуун	794,800.00	794,800.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	591,300.00	375,000.00	216,300.00	63.42
210404	Ном, хэвлэл	236,500.00	28,000.00	208,500.00	11.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	177,400.00	88,700.00	88,700.00	50.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,119,900.00	2,119,900.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,581,300.00</b>	<b>8,453,440.00</b>	<b>127,860.00</b>	<b>98.51</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	295,700.00	250,700.00	45,000.00	84.78
210502	Хоол, хүнс	7,516,900.00	7,434,040.00	82,860.00	98.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768,700.00	768,700.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>295,700.00</b>	<b>282,000.00</b>	<b>13,700.00</b>	<b>95.37</b>
210702	Дотоод албан томилолт	295,700.00	282,000.00	13,700.00	95.37
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>177,400.00</b>	<b>177,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,400.00	177,400.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,394,800.00</b>	<b>3,042,800.00</b>	<b>(648,000.00)</b>	<b>127.06</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,800.00	3,042,800.00	(648,000.00)	127.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,115,400.00</b>	<b>16,685,150.00</b>	<b>430,250.00</b>	<b>97.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,115,400.00</b>	<b>16,685,150.00</b>	<b>430,250.00</b>	<b>97.49</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	636,800.00	636,800.00	-	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,478,600.00	16,048,350.00	430,250.00	97.39
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>540,770,000.00</b>	<b>541,418,000.00</b>	<b>(648,000.00)</b>	<b>100.12</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>502,044,200.00</b>	<b>495,462,133.00</b>	<b>6,582,067.00</b>	<b>98.69</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	502,044,200.00	495,462,133.00	6,582,067.00	98.69
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>38,725,800.00</b>	<b>45,886,450.00</b>	<b>(7,160,650.00)</b>	<b>118.49</b>
132001	Орон нутгийн төсвөөс	38,725,800.00	45,886,450.00	(7,160,650.00)	118.49
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>-</b>	<b>69,417.00</b>	<b>(69,417.00)</b>	<b>-</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	69,417.00	(69,417.00)	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны
		Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,140,036.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,140,036.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,140,036.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,629,036.00</b>
210401	Бичиг хэрэг	712,936.00
210404	Ном, хэвлэл	916,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>590,800.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	590,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>415,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	415,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,505,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,505,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,140,036.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,140,036.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 11,757.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,405.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 11,519.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 9,215.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 237.7 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	56,580.5	71,379.6	14,799.1
Үндсэн хөрөнгө	740,754.4	712,715.3	(28,039.1)
Нийт хөрөнгө	<b>797,334.9</b>	<b>784,094.9</b>	<b>(13,240.0)</b>
Өр төлбөр	3,719.0	1,880.7	1,838.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>793,615.9</b>	<b>782,214.2</b>	<b>11,401.7</b>
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>797,334.9</b>	<b>784,094.9</b>	<b>13,240.0</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 71,379.6 мянган төгрөг болж, 14,799.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь Боловсролын газраас хандиваар ирсэн хичээлийн хэрэглэл, ариутгалын бодисын 1,336.1 мянган төгрөгөөр, малын нас дэвшилтийн болон төлийн орлогын 15,401.2 мянган төгрөгөөр, нийт 16,737.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 712,715.3 мянган төгрөг болж, 28,039.1 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс Боловсролын газраас хандиваар ирсэн номны 1,464.9 мянган төгрөгөөр, өөрийн орлогоор худалдан авсан хөрөнгийн 820.0 мянган төгрөгөөр нэмэгджээ. Үндсэн хөрөнгийн данс актлан данснаас хассан 25,228.0 мянган төгрөгийн дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 3,859.2 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 7,709.1 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ

Үндсэн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 12,574.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлэг байна. Энэ нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 540,770.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 540,770.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 540,770.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 540,770.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 502,044.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 38,725.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 541,418.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 541,418.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 534,820.7 мянган төгрөгийг зарцуулж, 6,597.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд малын орлогын 1,920.2 мянган төгрөгөөр, амьтан хамгаалах ажилд зориулсан 500.0 мянган төгрөгөөр, Боловсролын газраас ирсэн ариутгалын бодисын 295.4 мянган төгрөгөөр, түрээсийн сурах бичийн 1,424.4 мянган төгрөгөөр, нийт 4,140.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Бусад асуудлын хэсэг:**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 540,148.6 мянган төгрөгийн 20 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 540,148.6 мянган төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын Засгийн газрын хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 тогтоолын хэрэгжилтийг шалгахад орон тоо бүтэц нэмээгүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,568.1 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	1,568.1	1	1,568.1	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,568.1</b>	<b>1</b>	<b>1,568.1</b>	-	-	-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 546,906.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,183.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,694.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 542,029.3 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

##### 4.1 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн чадвараа алдсаны акттай 1 ажилтны 11-12 дугаар сарын цалингаас ХХОАТ-ын чөлөөлөлгүй тооцоноос 116.0 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д "Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна", "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Тэтгэвэрт гарсан 1 ажилтны 9 дүгээр сарын цалин, мөн 1 тэтгэвэрт гарсан ажилтны 9-12 дугаар сарын цалингаас НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцоноос 113.9 мянган төгрөгийг цалингаас илүү, ХХОАТ-ын 8.4 мянган төгрөгийг дутуу, 2.9 мянган төгрөгийг илүү, нийт 125.2 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д "Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна", ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 942.2 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.4.1-д " Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", "УСНББОУС 12 бараа материалд тавигдах шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

##### 4.2 Албан шаардлага

Нийт 6 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 3,694.2 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд 1,880.7 мянган төгрөгийн он дамжсан өр төлбөртэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,," заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсны дараа төлж барагдуулах

##### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 109 ширхэг 186,123.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

##### **3. Шилэн данстай холбоотой асуудал**

###### **3.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 540,148.6 мянган төгрөгийн 20 мэдээллийг ил тод байршуулахаас 540,148.6 мянган төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:</b>											
1	Хүнсний материалыг нөөцөлсөн	1	942.2			1	942.2				
2	Цалинг буруу тооцоолон олгосон	1	241.2			1	241.2				
3	Худалдан авалт Татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар баталгаажуулаагүй	1	3,694.2					1	3,694.2		
4	Өр төлбөр үүсгэсэн	1	1,880.7							1	1,880.7
5	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>6,758.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,183.4</b>	<b>1</b>	<b>3,694.2</b>	<b>2</b>	<b>1,880.7</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:</b>											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	540,148.6							1	540,148.6
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>540,148.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>540,148.6</b>
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>546,906.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,183.4</b>	<b>1</b>	<b>3,694.2</b>	<b>3</b>	<b>542,029.3</b>